



ДУАГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

**Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны
жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан /ДУАГ-
САБ/2017/02-ТЕЗ/**



**Батлагдсан төсөв өмнөх оноос өссөн харин
гүйцэтгэлийн хувьд буурсан байна.**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс
Дундговь аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Дарга, тэргүүлэх аудитор Т.ОЮУНЧИМЭГ	Бүлэг 1. Улсын төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь давуулан байна.....5
Аудитын менежер Х.НАРАНЦАЦРАЛ	1.1 Дээд шатны төсвөөс санхүүжилтийг бүрэн авсан байна.....5
Ахлах аудитор Б.ГАНТУЯА	1.2 Татварын орлого 2 хувиар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөр авч үзвэл 7 төрлийн орлого тасарсан байна.....6
Аудитор Т.ОЮУН-ЭРДЭНЭ	Бүлэг 2. Зардлыг бүлэг хооронд шилжүүлэн тодотгож, зардлын зүйлийн хувьд хэтрэлт гараагүй байна.....8
Шинжээч Ж.УГТАХБАЯР С.ЖАЛБАА	2.1 Нэмж тодотгосон зардлын 95.5 хувь нь тусгай зориулалтын сангийн зарцуулалт байна.....8
	2.2 Орон нутгийн төсвийн зардал зүйл бүрээр 79 -99 хувийн гүйцэтгэлтэй, хэтрэлтгүй байна.....10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7059-3113 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Дүгнэлт Зөвлөмж Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал тайлбар Тайлан баталгаажуулах тушаал Тайлангийн хавсралтууд
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 210 тоот	
2017 оны 4 дүгээр сар	

ТОВЧИЛСОН ҮГС

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИОТТХ	Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНО	Орон нутгийн орлого
ЗДН	Засаг даргын нөөц
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Дундговь аймгийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж, дүгнэлт гаргахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтыг дэвшүүллээ. Үүнд:

- Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг
- Орлогын гүйцэтгэл
- Зарлагын гүйцэтгэл
- Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Дараах хууль эрхийн актын холбогдох заалтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудитын хамрах хүрээ:

ТЕЗ-ийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг аж ахуйн нэгж байгууллага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016 оны санхүүгийн тайлан, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг мөрдөж, байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын судалгаа хийж, шаардлагатай горимыг хэрэгжүүлэн, нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, санхүүгийн аудитын багийн ахлах аудитор Б.Гантуяа, аудитор Т.Оюун-Эрдэнэ, шинжээч Ж.Угтахбаяр, С.Жалбаа нар гүйцэтгэсэн.

Бид Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитыг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 04 сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Бүлэг 1. Улсын төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь давуулсан байна.

1.1 Дээд шатны төсвөөс санхүүжилтийг бүрэн авсан байна.

УИХ-ын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан МУ-ын 2016 оны Төсвийн тухай хуульд Дундговь аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 6,962.0 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 4,852.1 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 22,198.3 сая төгрөгөөр тус тус баталж, тайлант онд Төсвийн тухай хуульд 1 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. /сая төгрөгөөр/

№	Эх үүсвэрийн нэр	УИХ-ын 2015.11.13	УИХ-ын 2016.09.09	Зөрүү
1	ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлэг	4,852.1	4,114.7	(737.4)
2	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	6,962.0	6,952.0	(10.0)
3	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	22,198.3	22,208.7	10.4
	Дүн	34,012.4	33,275.4	(737.0)

УИХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн тогтоолоор орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг 737.4 сая төгрөгөөр, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 10.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, тусгай шилжүүлгийн орлогыг 10.4 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Тайлант онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4,114.7 сая, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 6,952.0 сая төгрөг, тусгай зориулалтын

шилжүүлгээр 22,208.7 сая төгрөгийн санхүүжилт тус тус батлагдсаныг 100 хувь авсан байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг төрлөөр харуулбал:

- Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр 22,208.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, гүйцэтгэлээр 22,086.6 сая төгрөгийг зарцуулан, 122.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн.
- Орон нутгийн төсвөөс 12,760.5 сая төгрөгийн санхүүжилт авахаас 11,907.3 сая төгрөг буюу 853.2 сая төгрөгийг дутуу авч, гүйцэтгэлээр 11,545.6 сая төгрөгийг зарцуулан 361.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

1.2 Татварын орлого 2 хувиар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөр авч үзвэл 7 төрлийн орлого тасарсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн нийт орлогыг 4,660.3 сая төгрөгөөр анх баталж, төсөвт дараах өөрчлөлтүүдийг оруулжээ. /хүснэгт 2/

№	Үзүүлэлт	Төсөвт тодотгол хийсэн огноо дугаар			Хүснэгт 2 /сая төгрөгөөр/ Өөрчлөлт	
		2015.12.03 Дугаар 10	2016.09.23 №10	2016.12.02 №14	(2-1)	(3-2)
1	Татварын орлого	4,123.9	4,127.5	4,243.7	3.6	116.2
2	Татварын бус орлого	536.4	493.1	653.9	(43.3)	160.8
3	Төсөл сангийн орлого		2,311.2	2,474.4	2,311.2	163.2
4	Нийт орлого	4,660.3	6,931.8	7,372.0	2,271.5	440.2

ИТХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор нийт орлогыг 6,931.8 сая төгрөг, 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор орлогыг 7,372.0 сая төгрөг болгон тус тус тодотгосон байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 14 дүгээр тогтоолоор орлогын төлөвлөгөөг 7,372.0 сая төгрөгөөр баталсан. Үүнд татварын орлогыг 4,243.7 сая төгрөг, татварын бус орлогыг 3,077.4 сая төгрөг, хөрөнгийн орлого 50.9 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Татварын бус орлогын төлөвлөгөөний дүнд төсөл сангийн орлогын төлөвлөгөө 2,474.4 сая төгрөг орсон байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор баталсан төсвийн тодотгол нь 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-д /Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх шаардлага зайлшгүй бий болсон/ заасан шаардлагыг хангасан байна.

Тайлант хугацаанд 4,243.7 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,327.3 сая төгрөгийн орлого төвлөрч 83.6 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Хүснэгт 3 /сая төгрөгөөр/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого	3,393.0	3,266.8	(126.2)
Үйл ажиллагааны орлого	312.8	407.7	94.9
Хөрөнгө борлуулсны орлого	60.0	124.2	64.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(430.2)	(430.2)	0.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	75.0	84.3	9.3
Бууны албан татвар	21.7	17.7	(4.0)
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	200.0	204.9	4.9
Улсын тэмдэгтийн хураамж	85.0	97.4	12.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	45.0	30.6	(14.4)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	35.0	19.6	(15.4)
Газрын төлбөр	180.0	171.2	(8.8)
Дуудлага худалдаа	50.0	58.1	8.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	141.4	216.9	75.5
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	40.0	30.0	(10.0)
Бусад татвар	35.0	28.1	(6.9)
Татварын орлого	4,243.7	4,327.3	83.6

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн боловч орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого, бууны албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж, газрын төлбөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөр, бусад татвар тус тус тасарсан байна.

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлогын төлөвлөгөөг 3,393.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,266.8 сая төгрөг төвлөрүүлж, 126.2 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь цалин нэмэгдээгүй байхад өмнөх оноос төлөвлөгөөг 521.7 сая төгрөгөөр нэмж баталсантай холбоотой байна.
- Бууны албан татварыг 21.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 17.7 сая төгрөг төвлөрүүлж, 4.0 сая төгрөгөөр тасарсан. Тайлант онд Галт зэвсгийн албан татварын тухай хууль шинээр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус орлогыг өндөр төлөвлөсөн бөгөөд Цагдаагийн газарт бүртгэлтэй буу цөөн, галт зэвсгийн үзлэг явагдаж зөрчилтэй буунуудыг улсын орлого болгосонтой холбоотойгоор төлөвлөгөө тасарсан;
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 35.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 19.6 сая төгрөг төвлөрүүлж, 15.4 сая төгрөгөөр тасарсан байна. Аймаг, сумын удирдлагууд хуулинд заасан эрх үүргээ хэрэгжүүлээгүй, орлого бүрдүүлэхэд

санаачилга гаргаагүйтэй холбоотой орлого тасарсан. Үүнд Сайнцагаан сум тус орлогыг 18.1 сая төгрөгөөр тасалсан нь нөлөөлжээ.

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 45.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 30.6 сая төгрөг төвлөрүүлж, 14.4 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь улсын чанартай автозамын ажил дууссан боловч төлөвлөгөөг хасч батлаагүйтэй холбоотойгоор тасарчээ;
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 10.0 сая төгрөгөөр, газрын төлбөр 8.8 сая төгрөгөөр тус тус тасарсан нь аймгийн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсонтой холбоотой байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нийт дүнгээр, сум тус бүрээр авч үзэхэд дунджаар 9.9 хувиар давж биелүүлсэн боловч татварын нэр төрлөөр авч үзвэл бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын үйлчилгээний орлого, түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөр зэрэг орлогууд тасарсан байна. Орлого тасарсан шалтгааныг холбогдох сумдын мэргэжилтнээс тодруулахад орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй, өндөр төлөвлөсөн гэсэн тайлбарыг өгч байлаа. Сумдын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, тасарсан орлого, түүний шалтгааныг хүснэгт №1-д харууллаа.

Сумдад жил бүр тасарч байгаа дээрх нэр төрлийн орлогуудад судалгаа хийж, орлогыг бодитой төлөвлөх цаашид орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Бүлэг 2. Зардлыг бүлэг хооронд шилжүүлэн тодотгож, зардлын зүйлийн хувьд хэтрэлт гараагүй байна.

2.1 Нэмж тодотгосон зардлын 95.5 хувь нь тусгай зориулалтын сангийн зарцуулалт байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 сарын 03-ны өдрийн 10 дугаар тогтоолоор төсвийн зарлагыг 39,174.2 сая төгрөгөөр баталж, 2016 оны 09 сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 821.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 39,995.4 сая, 2016 оны 12 сарын 02-ны өдрийн 14 дугаар тогтоолоор 3,731.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 43,727.2 сая төгрөг болгож тус тус тодотгожээ.

№	Үзүүлэлт	Тодотгол хийгдсэн огноо		
		2015.12.03	2016.09.23	2016.12.02
1	Зарлага	39,174.2	39,995.4	43,727.2

/сая төгрөгөөр/

Дээрх хүснэгтээс харвал:

1. Орон нутгийн төсвийн зарлага:

- УИХ-ын тогтоолоор аймгийн ИТХ-ын төсвөөс орон нутгийн сонгуулийн зардал 189.2 сая төгрөг хасагдсан бөгөөд аймгийн ЗДТГ-т 70.0 сая, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 14.0 сая, аймгийн Засаг даргын нөөцөд 50.0 сая төгрөг тус тус нэмж нийт дүнгээрээ 55.2 сая төгрөгөөр буурсан.
- Өмнөх оны төсвийн хэмнэлт 57.6 сая төгрөг, орон нутгийн орлогын эхний үлдэгдэл 248.4 сая төгрөгийг тус тус нэмэгдүүлэн хуваарилсан байна.

2. ОНХС-ийн төсөв:

УИХ-аас 737.4 сая төгрөгөөр бууруулж, орон нутгийн давсан орлогын үлдэгдлээс 377.1 сая, ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс 916.3 сая, хандив, бусад эх үүсвэрээр 4.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

3. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зарлага: УИХ-аас 10.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

2016 оны 09 сарын 23-ны өдрийн төсвийн тодотголын өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 5 /сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	анхны батлагдсан төсөв	УИХ-аар тодотгосон	2016 оны эхний үлдэгдэл	2016 оны ОНО-ын эхний үлдэгдэл	хандив, бусад	тодотгосон төлөвлөгөө	өөрчлөлт
1	Орон нутаг	11,903.2	(55.2)		306.0		12,154.0	250.8
2	ОНХС	4,919.4	(737.4)	916.3	377.1	4.0	5,479.4	560.0
3	Тусгай шилжүүлэг	22,351.6	10.4				22,362.0	10.4
	дүн	39,174.2	(782.2)	916.3	683.1	4.0	39,995.4	821.2

Тодотголоор өөрчлөлт орсон зардлаас ОНХС-гийн зардал нь хөрөнгийн, бусад нь бараа үйлчилгээний урсгал зардал байна.

2016 оны 12 сарын 02-ны өдрийн тодотголоор нийт зардлыг 3,731.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосны 3,563.7 сая төгрөг буюу 95.5 хувь нь тусгай зориулалтын сангуудыг зарцуулах нэмж баталсантай холбоотой байна. Өөрөөр хэлбэл өмнөх жилүүдэд тусгай зориулалтын сангуудын /Сум хөгжүүлэх сан, Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сан, Ахмадын сан/ зарцуулалтыг төсвийн зарцуулалтад оруулж баталдаггүй байсан.

Хүснэгт 6 /сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2016.09.23	2016.12.02	өөрчлөлт
1	орон нутаг	12,154.1	12,254.0	99.9
2	ОНХС	5,479.4	5,529.1	49.7
3	Тусгай шилжүүлэг	22,361.9	22,380.4	18.5
4	Орон нутгийн тусгай сан		3,563.7	3,563.7
	дүн	39,995.4	43,727.2	3,731.8

Анхны батлагдсан төсвийг тодотгосон төсөвтэй харьцуулалт хийхэд анх батлагдсан төсвөөс нийт дүнгээрээ 4,553.0 сая төгрөгөөр буюу 11.6 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 7 /сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	өсөлт, (бууралт)	хувиар
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,353.4	18,310.4	(43.0)	99.8
2	Ажил олгогчоос төлөх НДШ	2,020.2	2,001.2	(19.0)	99.1
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,129.5	3,245.8	116.3	103.7
4	Хангамж, бараа материалын зардал	793.5	774.3	(19.2)	97.6
5	Нормативт зардал	1,609.3	1,408.5	(200.8)	87.5
6	Эд хогшил, урсгал засварын зардал	75.4	287.6	212.2	381.4
7	Томилолт, зочны зардал	114.9	150.9	36.0	131.3
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	1,295.9	913.3	(382.6)	70.5
9	Бараа үйлчилгээний бусад зардал	408.9	4,207.9	3,799.0	1029.1
10	Урсгал шилжүүлэг	5,953.8	5,976.1	22.3	100.4
11	Хөрөнгийн зардал	5,419.4	6,451.2	1,031.8	119.0
дүн		39,174.2	43,727.2	4,553.0	111.6

Зардлын төрлөөр авч үзвэл цалин, НДШ, хангамжийн материалын зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 19.0-382.6 сая төгрөгөөр буурсан. Байр ашиглалтын тогтмол зардал, томилолт, хөрөнгийн, бараа үйлчилгээний бусад зардал 36.0-3,799.0 сая төгрөгөөр өссөн байна.

2.2 Орон нутгийн төсвийн зардал зүйл бүрээр 79 - 99 хувийн гүйцэтгэлтэй, хэтрэлтгүй байна.

Тайлант онд нийт зардлыг 43,727.3 сая төгрөгөөр төлөвлөж, 39,572.9 сая төгрөг буюу 90.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан. Хүснэгтээс харахад бараа үйлчилгээний бусад зардал, татаас ба урсгал шилжүүлгийн зардлын гүйцэтгэл 79-83 хувь байна.

Хүснэгт 8 /сая төгрөгөөр/

№	Нийт зардал	2016 он				
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэсэн (Хэтэрсэн)	Гүйцэтгэлийн хувь	Эзлэх хувь
1	Ажиллагсадтай холбогдсон зардал	20,311.6	20,270.7	41.0	99.80	51.2
2	Бараа үйлчилгээний бусад зардал	10,988.3	8,754.4	2,233.9	79.67	22.1
3	Татаас ба урсгал шилжүүлэг	5,976.1	4,970.2	1,005.9	83.17	12.6
4	Хөрөнгийн зардал	6,451.2	5,577.6	873.6	86.46	14.1
Нийт дүн		43,727.3	39,572.9	4,154.4	90.50	100.00

Нийт зардлын бүтцийг диаграмаар харуулбал:




Гүйцэтгэлээрх нийт зардлын 51.0 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 22.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 13 хувийг татаас ба урсгал шилжүүлэг, 14 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Төсвийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал төлөвлөгөө 961.6 сая төгрөгөөр өсч, гүйцэтгэл 197.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9 /сая төгрөгөөр/

№	Урсгал зардал	2015 он		2016 он		Харьцуулалт өссөн +/- буурсан +/-	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Ажиллагсадтай холбогдсон зардал	20,529.8	20,298.0	20,311.6	20,270.7	(218.2)	(27.4)
2	Бараа үйлчилгээний бусад зардал	6,397.1	6,267.8	10,988.3	8,754.4	4,591.2	2,486.6
3	Татаас ба урсгал шилжүүлэг	5,902.6	4,980.9	5,976.1	4,970.2	73.6	(10.7)
4	Хөрөнгийн зардал	9,936.2	8,223.5	6,451.2	5,577.6	(3,485.0)	(2,645.9)
Нийт дүн		42,765.7	39,770.2	43,727.3	39,572.9	961.6	(197.3)

Тайлант оны төлөвлөгөө өмнөх оноос өссөн ч гүйцэтгэлээр өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Харин бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос 2,486.6 сая төгрөгөөр өсч, хөрөнгийн зардал 2,645.9 сая төгрөгөөр буурсан байна.



2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор батлагдсан УИХ-ын 47 дугаар тогтоолыг хэрэгжүүлж батлагдсан төсвийг хэмнэж ажилласан нь графикаас харагдаж байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг нэр төрлөөр бүртгэн, зардлын зүйл тус бүрээр эрх нээн зарцуулж, тайлагнажээ.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 835.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны эх үүсвэрийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10 /сая төгрөгөөр/				
№	Нэмэлт төсвийн эх үүсвэр	2015 он	2016 он	Өсөлт/ (Бууралт)
1	Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	9.8	3.6	(6.2)
2	Засгийн газрын нөөц хөрөнгө, ЗДН хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө	64.8	64.3	(0.5)
3	Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид	694.2	626.0	(68.2)
4	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	79.5	67.5	(12.0)
5	Төсвийн урамшуулал	30.6	73.8	43.2
6	Өмнөх оны үлдэгдэл	85.4		
Дүн		964.3	835.2	(43.7)

Судалгаанаас харахад санхүүжилт урьд оноос 43.7 сая төгрөгөөр буурсан байна.

Нэмэлт төсвийн зарцуулалтыг диаграммаар харуулбал:

Нийт зардлын 86.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 4.0 хувийг ажиллагсадтай холбогдсон зардалд, 10.0 хувийг татаас урсгал шилжүүлгийн зардалд тус тус зарцуулжээ.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Дээд шатны төсвөөс санхүүжилтийг бүрэн авсан байна.
2. Татварын орлого 2 хувиар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөр авч үзвэл 7 төрлийн орлого тасарсан байна.
3. Нэмж тодотгосон зардлын 95.5 хувь нь тусгай зориулалтын сангийн зарцуулалт байна.
4. Орон нутгийн төсвийн зардал зүйл бүрээр 79 - 99 хувийн гүйцэтгэлтэй, хэтрэлтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг даргад:

1. Жил бүр тасарч байгаа нэр төрлийн орлогуудад судалгаа, дүгнэлт хийж орлогыг бодитой төлөвлөн, төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлэхэд анхаарч ажиллах

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Б.ГАНТУЯА

АУДИТОР

Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ШИНЖЭЭЧ

Ж.УГТАХБАЯР

ШИНЖЭЭЧ

С.ЖАЛБАА

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/7

Мандалговь

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалын 9, 11, 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан /ДУАГ-2017/1-СТА-ТЕЗ/-г баталсугай.


2. Аудитаар илэрсэн зөрчил, акт, албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. "Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2017 оны 06 дугаар сарын 20-ны дотор Аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/, ерөнхий санхүүч /С.Энхжаргал/-нарт тус тус зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 3 дугаар улиралд гарган танилцуулахыг Аудитын менежер /Х.Наранцацрал/, санхүүгийн аудитын багийн ахлах аудитор /Б.Гантуяа/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ОЮУНЧИМЭГ

D:\office\Tushaal\A4\Batalgaajuu lakh.docx

0000000022

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

№	Сум	ӨССӨН				Тасарсан орлогын төрөл	Тасарсан орлогын дүн	Тасарсан орлогын шалтгаан
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь			
1	Дэлгэрцогт	89.5226	94.64139114	5.11879114	105.7	Бууны албан татвар	0.2	Цагдаагийн газраас галт зэвсгийн нэгдсэн үзлэг явагдаж 9 ширхэг зөрчилтэй буу илрүүлж улсын орлого болгосонтой холбоотойгоор төлөвлөгөө тасарсан байна.
						Улсын тэмдэгтийн хураамж	0.4	Бодитой төлөвлөөгүйгээс орлого тасарсан.
						Хог хаягдлын үйлчилгээ	0.9	Орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн хог хаягдлын орлого тасарсан байна.
						Түгээмэл тахарцтай ашигт малтмал ашигласны татвар	3	Тайлант онд зам анги татан буугдсанаас түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны орлого тасарсан байна.
2	Дэрэн	129.0116	154.2467606	25.2351606	119.6	Бууны албан татвар	0.2	Суманд бүртгэлтэй буунаас илүү, өндөр төлөвлөгөө өгсөнтэй холбоотойгоор бууны татвар тасарсан.
						Түгээмэл тахарцтай ашигт малтмал ашигласны татвар	1.3	Тайлант онд байгалийн баялаг ашигласан иргэд, аж ахуйн нэгж байхгүйгээс түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр тасарсан
3	Говь-Угтаал	148.4839	155.6927569	7.20885686	104.9	Бууны албан татвар	1,2	Суманд бүртгэлтэй буунаас илүү, өндөр төлөвлөгөө өгсөнтэй холбоотойгоор бууны татвар тасарсан.
						Улсын тэмдэгтийн хураамж	0,8	Засаг даргын Тамгын газрын даргаар наториатын эрхгүй хүн /үүрэг гүйцэтгэгчээр/ 11 сарын хугацаатай ажилласнаас орлого тасарсан
						Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	4	Тайлант онд байгалийн баялаг ашигласан иргэд, аж ахуйн нэгж байхгүйгээс түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр тасарсан
4	Цагаандэлгэр	103.4888	110.9678615	7.47906152	107.2	ИОТХ	5.3	

						Бууны албан татвар	0.7	Орон тооны татварын байцаагчгүйгээс татварын орлого бүрдүүлэх талаар ажлыг цалгардуулж орлогын төлөвлөгөө тасалсан /татварын байцаагчийн ажлыг тайлант оны 10 сарын хугацаанд Санхүүгийн албаны дарга хавсарч ажилласан/
						Улсын тэмдэгтийн хураамж	0.8	
						Хог хаягдлын үйлчилгээ	0.2	
						Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.1	
5	Баянжаргалан	166.0506	167.9403964	1.88979642	101.1	Бууны албан татвар	0.3	Цагдаагийн байгууллагад бүртгэлтэй галт зэвсгийн тооноос илүү, өндөр төлөвлөгөө өгсөнтэй холбоотойгоор бууны татвар тасарсан.
						Улсын тэмдэгтийн хураамж	0.8	Наториат болон улсын бүртгэгч, газрын даамлын үйлчилгээнээс боломжит орлогууд орсон боловч тасарсан. Өмнөх онд тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн эрх сунгах тэмдэгтийн хураамжаас орлогоос төлөвлөгөөг биелүүлж ажилласан байна.
6	Өндөршил	114.1626	128.6011562	14.43855622	112.6	Улсын тэмдэгтийн хураамж	0.6	Тайлант онд байгалийн баялаг ашигласан иргэд, аж ахуйн нэгж цөөн байснаас түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого тасарсан,
						Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.9	Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийг бодитой төлөвлөөгүй байна. Мөн согтууруулах ундаа, тамхины зөвшөөрөл 2016 онд олгогдоогүй.
7	Гурвансайхан	217.192	306.1910728	88.99907283	141.0	Бууны албан татвар	0.1	
						Хог хаягдлын үйлчилгээ	0.2	
						Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	3	
8	Өлзийт	147.1682	168.5612166	21.39301662	114.5	Хог хаягдлын үйлчилгээ	0.1	Уул уурхайн орлогыг өндөр төлөвлөж уул уурхай ажиллагаагүй байгаатай холбоотой орлого тасарсан байна.
						Бууны албан татвар	0.3	Суманд бүртгэлтэй буунаас илүү, өндөр төлөвлөгөө өгсөнтэй холбоотойгоор бууны татвар тасарсан.

9	Хулд	174.0106	178.0317311	4.02113111	102.3	Хог хаягдлын үйлчилгээ	0.6	орлогын төлөвлөөг бодитоор төлөвлөөгүйгээс шалтгаалсан
						Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.3	
10	Луус	89.2726	99.21103247	9.93843247	111.1	Бууны албан татвар	0.2	Улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төлөвлөгөө өндөр төлөвлөгдсөнөөс орлого тасарсан байна.
						Улсын тэмдэгтийн хураамж	0.1	Суманд бүртгэлтэй буунаас илүү төлөвлөгөө батлагдсан. Энэ төрлийн орлого тасрах шалтгаан болсон байна.
						Хог хаягдлын үйлчилгээ	0.2	Хог хаягдал Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол хэрэгжүүлж ажиллагаагүйгээс орлогын төлөвлөгөө тасарсан.
						Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.1	Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын төлөвлөөг бодитой төлөвлөөгүй.
11	Дэлгэрхангай	101.3126	122.1419972	20.8293972	120.6	Бууны албан татвар	0.3	Улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төлөвлөгөө өндөр төлөвлөгдсөнөөс орлого тасарсан байна.
						Улсын тэмдэгтийн хураамж	0.1	Суманд бүртгэлтэй бууны тоог үндэслээгүй /илүү төлөвлөсөн/ төлөвлөгөөг баталсан нь орлого тасрах шалтгаан болсон байна.
						Хог хаягдлын үйлчилгээ	0.3	Хог хаягдлын орлогыг бодитоор төлөвлөж батлаагүй байна.
						Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.1	Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогыг бодитой төлөвлөж батлаагүй байна.
12	Сайхан-Овоо	92.2007	99.53742396	7.33672396	108.0	Бууны албан татвар	0.3	орлогын төлөвлөөг бодитоор төлөвлөөгүйгээс шалтгаалсан
						Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.1	
13	Эрдэнэдалай	257.6576	267.3769522	9.71935219	103.8	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.8	орлогын төлөвлөөг бодитоор төлөвлөөгүйгээс шалтгаалсан

14	Сайнцагаан	339.9346	359.4603009	19.52570085	105.7	Хог хаягдлын үйлчилгээ	18.1	Сумын удирдлагууд хуулинд заасан эрх үүргээ хэрэгжүүлээгүй, орлого бүрдүүлэхэд санаачилга гаргаагүйтэй холбоотой орлого тасарсан.
15	Адаацаг	116.6326	126.457651	9.82505098	108.4	Бууны албан татвар	0.2	орлогын төлөвлөөг бодитоор төлөвлөөгүйгээс шалтгаалсан
16	Дундговь	2367.11856	2194.575822	-172.5427377	92.7	Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татвар	239.7	цалин, хөлс нэмэгдээгүй байхад өмнөх оноос нэмж баталсантай холбоотой байна
						Газрын төлбөр	3.1	
Нийт дүн		4653.2	4733.6	80.4				